



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 348

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Таван толгой түлш” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 459,188,729.00 (дөрвөн зуун тавин есөн сая нэг зуун наян найман мянга долоон зуун хорин есөн) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг “Дулааны хоёрдугаар цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанид балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Насантогтох, “Таван толгой түлш” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал М.Ганбаатар, “Дулааны хоёрдугаар цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал С.Бямбаахүү нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Компанийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

300683

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 07 дугаар сарын 17 ны өдрийн
348 дугаар тогтоолын хавсралт

**ТАВАН ТОЛГОЙ ТҮЛШ ХХК-ИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ "ДУЛААНЫ ХОЁРДУГААР
ЦАХИЛГААН СТАНЦ" ТӨХК-Д БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын үнэ (төгрөг)
1	Шахмал түлшний үйлдвэрийн дулаан хангамжийн тоноглол	1/1/2017	ком	1	459,188,729.00
Нийт дүн					459,188,729.00
					(Дөрвөн зуун тавин есөн сая нэг зуун найян найман мянга долоон зуун хорин есөн)